



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

**Явган зорчигчийн гэрэлтүүлэг  
суурилуулах тухай**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.5.4 дэх заалт, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/179 дүгээр “Эрх шилжүүлэх тухай” захирамж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 17 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт “дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, явган зорчигч, хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилсан сэргийлэх зорилгоор дүүргийн ерөнхий боловсролын 24, 37, 49, 57, 138, 139, 140, 149 дүгээр сургуулиудын ойролцоох авто замын явган зорчигчийн гарцад авто зам руу тусдаг лед гэрэлтүүлэг суурилуулах ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэй хийж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.

2.Шаардагдах зардал 75,000,000 (далан таван сая) төгрөгийг Хурлын төсвийн Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж (Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх)-ийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Туяа)-нд зөвшөөрсүгэй.

3.Худалдан авсан бараа, ажлын тайлан мэдээг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2023 оны 12 дугаар сард багтаан эргэн тайлагнахыг дүүргийн Худалдан авах ажиллагааны алба (дарга Т.Отгонбаяр)-нд үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын алба (дарга Т.Идэрцагаан)-нд даалгасугай.


ДАРГА



Б.МӨНХБАТ

1150100100

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 28 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Явган зорчигчийн гэрэлтүүлэг суурилуулах сургуулийн нэрс

Д/д	Ерөнхий боловсролын сургууль	Замын эгц дээрээс лед гэрэл суурилуулах байршил	Авто замын өргөн	Олон чиглэлээр ашиглах Төмөр шон
1	24-р сургууль	Баруун хойно	7 метр	Төмөр шон хийнэ
2	37-р сургууль	Зүүн хойд тал	7,1 метр	Төмөр шон хийнэ
3	49-р сургууль	Баруун талд	7 метр	Төмөр шон байгаа
4	57-р сургууль	Зүүн урд талд	13,9 метр	Төмөр шон байгаа
5	138-р сургууль	Зүүн талд	6,3 метр	Төмөр шон хийнэ
6	139-р сургууль	Урд талд	6,3 метр	Төмөр шон хийнэ
7	140-р сургууль	Зүүн талд	7,5 метр	Төмөр шон хийнэ
8	149-р сургууль	Зүүн урд талд	6 метр	Төмөр шон хийнэ

УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНИЙ СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮСИЙН  
ЯВГАН ЗОРЧИГЧИЙН ГАРЦЫН ГЭРЭЛТҮҮЛЭГ ХИЙЛГЭХ СУДАЛГАА

2023.11.23

Улаанбаатар хот

Д/д	Дүүрэг хороо	Байршил	Сургууль	Замын өргөн эгнээ	Гэрэлтүүлэгтэй эсэх		Тэмдэглэй эсэх		Хэвийн	Бүдгэрсэн муудсан	Шинээр суурилуулах шаардлагатай эсэх
					Асдаг	Асдаггүй	5/25	5/26			
Чингэлтэй дүүрэг											
1	23-р хороо	зүүн талд	140-р сургууль	7.5м			тийм	тийм		муудсан	тийм
2	2-р хороо	баруун хойд	24-р сургууль	7м			тийм	тийм		муудсан	тийм
3	17-р хороо	зүүн хойд тал	37-р сургууль	7.10м			тийм	тийм	хэвийн		тийм
4	15-р хороо	баруун тал	49-р сургууль	7м		тийм	тийм	тийм	хэвийн		тийм
5	22-р хороо	урд талд	139-р сургууль	6.3м		тийм	тийм	тийм		муудсан	тийм
6	11-р хороо	зүүн урд талд	57-р сургууль	13.90м		тийм	тийм	тийм	хэвийн		тийм
7	12-р хороо	зүүн талд	138-р сургууль	6.30м		тийм	тийм	тийм		муудсан	тийм
8	21-р хороо	зүүн урд талд	149-р сургууль	6м			тийм	тийм	хэвийн		тийм



**НИЙСЛЭЛИЙН ГЭМТ ХЭРГЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160 0035  
Утас: (976-11) 32 58 26  
Цахим шуудан: info@citycouncil.ub.gov.mn  
Цахим хуудас: khural.ulaanbaatar.mn

2023.11.20 № 08-2/16

тайай \_\_\_\_\_ -ийн № \_\_\_\_\_ -г

**Мэдээлэл хүргүүлэх тухай**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/179 тоот захирамжаар "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Ерөнхий боловсролын сургууль орчмын бүсэд явган хүний гарцын гэрэлтүүлэг" байрлуулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэсэн.


Тус захирамжийн дагуу худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, ажлын зураг боловсруулах даалгаварт заасан стандарт шаардлагад нийцүүлэн зохион байгуулж ажиллана уу.


1 дүгээр хавсралт: хавсралт, 3 хуудастай.

2 дугаар хавсралт: хавсралт, 11 хуудастай.



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ТБАГ  
Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл  
Нарийн бичгийн дарга  
Баттулга Батбямба  
2023.11.20 15:39



БАТЛАВ  
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  М БАЯРАА

СУРГУУЛЬ ОРЧМЫН ЯВГАН ХҮНИЙ ГАРЦЫН "ЛЕД ПРОЕКТОР" ГЭРЭЛТҮҮЛГИЙН  
АЖЛЫН ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр Дугаар .... Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2023 оны үйл ажиллагааны хөтөлбөр;</li><li>- Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2023 онд хөгжүүлэх үндсэн чиглэл</li></ul>
2	Байршил	Нийслэлийн 9 дүүргийн сургууль орчмын явган хүний гарц
3	Одрогийн байдал	Сургуулийн орчмын бүсэд зарим гарцууд гэрлэн дохиогүй, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад стандартын тэмдэг тэмдэглэгээ бүхий гарцгүй, зарим байршилд зам тээврийн осол хэрэг давтамжтай үйлдэгддэг <ul style="list-style-type: none"><li>- ЛЕД проектор гэрэлтүүлэг хийгдээгүй</li><li>- Шинээр төлөвлөх</li><li>- Судалгаа хийх</li></ul>
4	Зураг төсөв боловсруулахад ашиглах материал	Норм нормативууд. <ul style="list-style-type: none"><li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li><li>- Цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм" БД 43.101.03</li><li>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21.02.02</li><li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-10-04)</li><li>- Хот, тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх /БД 30-102-11/</li><li>- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНБД 23-02-08/;</li><li>- Гэрэлтүүлэгт тавигдах ерөнхий шаардлага" хотын стандарт UCS1902B:2022</li><li>- Гэрэлтүүлэх төхөөрөмжийг байрлуулах, суурилуулах технологийн удирдамж хотын стандарт UCS1902A:2022</li><li>- Бусад холбогдох норм дүрэм, заавар</li></ul>
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
7	Төсөл боловсруулах байгууллага	Тусгай зөвшөөрөлтэй гүйцэтгэгчийг шалгаруулна.
8	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	Хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн норм дүрмийн дагуу онцлох хэв маяг шийдлийг тусгаж өгөх; Гэрэлтүүлгийн шонг цаашид өргөтгөх боломжтойгоор зураг төсөлд тусгах
9	Инженерийн хангамж	<ul style="list-style-type: none"><li>- Техникийн нөхцөл, БНБД, БД, холбогдох стандартад тавигдсан шаардлагын дагуу тоног төхөөрөмж, кабель шугам, материалыг сонгох</li><li>- Гэрэлтүүлгийн кабелийн шугамын сувагчлалыг UCS1902B:2022 UCS1902A 2022 стандартын дагуу хийх</li></ul>

		- Цахилгаан хангамж: Төвлөрсөн цахилгаан хангамжийн шугам сүлжээнээс хангагдана.
10.	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR -PRO программ болон түүнтэй ижил, цалинг дундаж зэргээр тооцдог, зохих эрх бүхий, байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно
11	Төслийн санхүүжилт	- Нийслэлийн төсвийн хөрөнгө
12	Төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Зураг төслийн баримт бичиг 4 хувь Үүнээс график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид үндсэн хувийг архивт өгөх.</li> <li>- Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр УБЗАА, нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгөх.</li> <li>- Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөх</li> <li>- UB инженеринг цахим системд бүртгүүлэх</li> </ul>
13.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Цахилгааны шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх</li> <li>- Төлөвлөж буй цахилгаан хангамжийн шугам сүлжээнд одоо холбогдсон болон төлөвлөлтөөр холбогдох хэрэглэгчдийн ачааллыг тусгасан байх</li> <li>- Ойр орчмын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч компаниудын цахилгаан хангамжийн трасстай уялдуулан төлөвлөсөн байх</li> <li>- Авто замын зорчих хэсэгт төлөвлөсөн инженерийн шугам сүлжээний хонгилын системтэй уялдуулах</li> <li>- Зургийн төслийн ажлыг боловсруулахдаа дүүрэг, ашиглалт хариуцсан байгууллагатай газар дээр нь үзлэг хийж судалгаа гаргах <ul style="list-style-type: none"> <li>- Шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зай хэмжээ баримтлах</li> <li>- Эрчим хүчний хэмнэлттэй лед болон түүнтэй дүйцэхүйц шар тусгалтай гэрэлтүүлэгч сонгоно</li> <li>- Инженерийн хангамжийн асуудлыг тооцоо, судалгааны үндсэн дээр хийх</li> <li>- Гэрэлтүүлгийн зураг төсвийг гүйцэтгэхдээ доорх техникийн үзүүлэлтийг харгалзан үзнэ.</li> <li>- Зам хөндлөн гарах гэрэлтүүлгийн кабелийн сувагчлалыг даацын хоолой, ус чийг тусгаарлалт сайтай материалаар хийж гүйцэтгэх</li> </ul> </li> </ul>
14	Техникийн тодорхойлолт	<ul style="list-style-type: none"> <li>- Явган замын тэмдэглэгээг / -40, +40 / халуун хүйтэнд тэсвэртэй, нарны хэт туяа, шуурга, доргилтонд тэсвэртэй, Gobo технологиор гэрэлтүүлэгтэйгээр шийдэх.</li> </ul> <p>Хүчин чадал</p> <ul style="list-style-type: none"> <li>-Өндөр нягтралтай ЛЕД чиптай байх.</li> <li>- 5-7 жил тасралтгүй ажиллах насжилтай байх.</li> <li>- Хүчин чадал 320 ватт</li> <li>- Үндсэн тэжээл 220В</li> <li>- Өнгө 8000К</li> <li>- IP65 ба түүнээс дээш байх</li> </ul>



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, 46.5.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Дүүргүүдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, орон нутгийн онцлог, үйл ажиллагаатай уялдуулан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Ерөнхий боловсролын сургууль орчмын бүсэд гэрлэн гарц бүхий лед гэрэлтүүлгийг стандарт шаардлагад нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах эрхийг дүүргүүдийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд шилжүүлсүгэй.

2. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайланг 2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд ирүүлэхийг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нарт даалгасугай.

3. Шаардагдах зардлыг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвөөс гаргахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн Санхүү, аж ахуйн тасаг (Ш.Шадвийдорж)-т зөвшөөрсүгэй.

4. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга Б.Батбямбад даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын даргын 2023 оны 1 дүгээр  
сарын 17 ны өдрийн 179 дугаар  
захирамжийн хавсралт

ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

(төгрөгөөр)

№	Байгууллага	Лед гэрэлтүүлэг, шонгийн төсөв
1	Чингэлтэй дүүргийн ГХУСАЗСЗ	75,000,000
	Нийт	75,000,000

---oOo---